



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 5/52

Хэрлэн сум

Б.Мягмарсүрэнг гэрээгээр
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасагт Бүжинхүүгийн Мягмарсүрэнг 2022 оны 6 дугаар сарын 07-оос 2022 оны 6 дугаар сарын 24-ийг хүртэл хугацаагаар төрийн архивын дансанд нягтлан шалгалт хийлгэхээр түр томилон ажиллуулсугай.

2.Гэрээт ажилтны цалинг 270000 (хоёр зуун далан мянга) төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэл, татварыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3.Гэрээт ажилтныг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Архивын тасгийн Сан хөмрөгийн эрхлэгч (Б.Оюунтуяа)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР